Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 04-ний өдрийн 09 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906
9023111371

## БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
## "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо[1] | Хувийн жин[2] |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ) | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлсан эсэх[4] | | 1 | 1 | 100 |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5] | | 1 | 1 | 100 |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6] | 0,5 | 0,5 | 100 |
| | | | Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7] | 0,5 | 0,5 | 100 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8] | 0,5 | 0 | 0 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүрттэлийн маягт бөглөсөн байдал[9] | 0,5 | 0,5 | 100 |
| Хэсгийн оноо | | | | 4 | 3,5 | |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ) | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)* | | 1 | 0,5 | 50 |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11] | | 1 | 1 | 100 |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12] | | 1 | 1 | 100 |
| Хэсгийн оноо | | | | 3 | 2,5 | |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ) | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13] | | 1 | 1 | 100 |
| 8 | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)* | | 1 | 0,5 | 50 |
| 9 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15] | | 1 | 1 | 100 |
| Хэсгийн оноо | | | | 3 | 2,5 | |
| Үнэлгээний нийт оноо, хувь | | | | 10 | 8,5 | 85 |

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

**Тайлбар:**

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүрттэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүрттэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүрттэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

# МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2026.01.05

НЭГ. Товч танилцуулга

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг тус тус үндэслэн Монополын эсрэг газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлж, санал хурааснаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

➢ Үйл ажиллагааны төлөвлөгөө:

Ёс зүйн дэд хороо 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн оны 01 дүгээр сарын 20-ны өдөр, хорооны гишүүдийн ажлын чиг үүргийг 01 дүгээр сарын 23-ны өдөр тус тус хэлэлцэж, баталсан бөгөөд "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд төлөвлөгөө болон холбогдох баримтуудыг тухай бүр байршуулан ажиллаж байна.

➢ Ёс зүйн сургалт:

1. 2025 оны 4 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд байгууллагын албан хаагчдыг “Байгууллагын эерэг соёлыг бүрдүүлэх нь”, мөн “Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ.” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.






2. 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Улсын Ерөнхий Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавих хэлтсээс “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хэрэглээний талаар болон Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ, анхаарах асуудал, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн ялгааг

хэрхэн хангаж ажиллах улсын байцаагчдыг чадавхжуулах зорилго бүхий сургалтыг зохион байгуулсан.



3. Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр "Төрийн албан хаагчдын нэгдсэн стандарт"-ын дагуу байгууллагын стандартыг баталж, мөрдүүлэх шаардлагатай эсэх, төрийн албан хаагчийн хувцаслалт /дүрэмт хувцас/-ын асуудлаар нийт албан хаагчдыг хамруулан хэлэлцэж, санал солилцох уулзалт, арга хэмжээг хийсэн.

4. "Авлигын эсрэг нэгдье" аяны хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус газрын "Хэрэглэгчийн мэдээллийн төв"-ийн 115 утасны дугаараар иргэдийн гомдол, саналыг хүлээн авч байгаа талаар байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,








үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд "Давамгай байдалтай хуулийн этгээд нэгдэх, нийлэх" сэдвээр шинээр өрсөлдөөний асуудлыг шийдвэрлэж буй албан хаагчдыг чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан.

5. 2025 оны 08 дугаар сарын 15 болон 09 дүгээр сарын 10-ны өдрүүдэд Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд ёс зүйн асуудлаар хоёр удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

➢ <u>Соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлууд</u>:

1. Байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг боловсруулж, нэгжийн дарга нарт хүргүүлж, байгууллагын хурлын танхимд болон албан өрөөнүүдэд тус тус байршуулсан.









2. “Ёс зүйтэй, үлгэр жишээ-Төрийн албан хаагч” болзолт уралдаан

Агентлагийн даргын 2025.10.17-ны өдрийн А/72 дугаар тушаалын хавсралтаар “Ёс зүйтэй, үлгэр жишээ-Төрийн албан хаагч” болзолт уралдааны удирдамжийг батлуулж, дүгнэж ажиллалаа. Ажлын цаг баримталдаг, цаг ашиглалтыг үр бүтээлтэй өнгөрүүлсэн болон ажлын байранд харилцааны ёс зүйтэй, албан хувцаслалтын шаардлагыг баримталж, хамт олон дотроо үлгэр жишээ үзүүлж ажилласан тус тус 1 албан хаагчийг, мөн “Эртэч шувуухай-мэдээллийн цаг”-аар “Цаг ашиглалт /timely/-ын ухаалаг систем” болон сэтгэл зүйн “Харилцаа хандлага, амьдралын чанар” сэдвүүдээр мэргэжлийн байгууллагаас багш нарыг урьж, оролцуулан албан хаагчдад сонирхолтой, шинэлэг мэдээллийг түгээсэн 1 нэгжийг тус тус урамшуулж ажилласан байна.







3. Байгууллагын албан ёсны цахим хуудсанд “Ёс зүйн дэд хороо” булан нээж, хорооны 2025 оны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэйгээр мэдээлэл хүргэн ажиллаж байна.




4. Байгууллагын нийт албан хаагчдыг хамруулан “Ажлын байрны дарамтын нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”-г явуулж, нэгтгэн дүгнэж, байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулсан.




5. Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас”-ыг байгууллагын албан хаагчдаар үнэлүүлсэн байна.

**2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:**

1. 2025 оны байдлаар дотоод нэгжийн албан хаагчаас ёс зүйн асуудлаар 1 гомдол ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан шалгаж, шийдвэрлэсэн дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан бөгөөд ёс зүйн зөрчил мөн гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй тул томилох эрх бүхий албан тушаалтнаас шийдвэр гараагүй бөгөөд хуулийн хугацаанд цахим системд дүгнэлт болон холбогдох материалыг байршуулсан.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн агентлагийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.

**2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:**

1. Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, мэдээллийг тухай бүр бүртгэж, албажуулсан байна;

2. 2025 оны 08 дугаар сард дотоод нэгжийн албан хаагчаас ёс зүйн асуудлаар ирүүлсэн гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан шалгаж, журмын дагуу хорооны хурлаар танилцуулж, хэлэлцэн шийдвэрлэсэн дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан ба хуулийн хугацаанд цахим системд дүгнэлт болон холбогдох материалыг байршуулсан;

3. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг хуулийн хугацаанд тухай бүр бүртгэж,тайлагнаж ажилласан.

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

БАТЛАВ.
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Х.ОРХОН

# МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.20

| Д/д | Хэрэгжүүлэх ажил | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| 1 | Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, батлах | 1-р сард | ЁЗДХ-ны дарга |
| 2 | Дэд хорооны гишүүдийн ажлын чиг үүргийг батлах, гомдол, мэдээллийг хуваарилах | | |
| 3 | Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах | 4-9-р сард | Тамгын газар /жилд 2-оос доошгүй/ |
| 4 | Шинээр орсон ажилтанд чиглүүлэх сургалтыг хүний нөөц, сургалт хариуцсан албан хаагчтай хамтран зохион байгуулах | Тухай бүр | Тамгын газар, /нийт 8 цагийн сургалт/ |
| 5 | Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд хянан шалгаж, дүгнэлт гаргах | Тухай бүр | ЁЗДХ-ны гишүүд |
| 6 | Байгууллага дотор гарч байгаа болон үүсч болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, ажлын хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн судалгаа”-г явуулах | Жилдээ | ЁЗДХ-ны дарга, гишүүд |
| 7 | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээрх зөвлөмжийг дотоод хяналт хариуцсан нэгж эсхүл албан хаагчид хүргүүлэх | 3-р сард | ЁЗДХ-ны дарга, гишүүд |
| 8 | Дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд оруулж, биелэлтийг тухай бүр оруулах | Тухай бүр | ЁЗДХ-ны нарийн бичгийн дарга |
| 9 | Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, томилох ЭБАТ-ны хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг “Ёс зүйн мэдээллийн цахим сан” болон байгууллагын цахим хуудсанд байршуулах | Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор | ЁЗДХ-ны нарийн бичгийн дарга |
| 10 | Үйл ажиллагааны жилийн тайланг хуулийн хугацаанд “Ёс зүйн мэдээллийн цахим сан” болон байгууллагын цахим хуудсанд байршуулах | Дараа оны 1-р сарын ажлын сүүлийн өдрийн дотор | ЁЗДХ-ны нарийн бичгийн дарга |
| 11 | Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх “Үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Жилдээ | ЁЗДХ-ны дарга, гишүүд |